# ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР № 16

Хуралдаан 2013 оны тавдугаар сарын 23-ны өдрийн 15 цаг 50 минутад эхэлж, 17 цаг 03 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 1 цаг 13 минут үргэлжлэв.

| № | Хэлэлцсэн асуудал | Гарсан шийдвэр |
|---|---|---|
| 1 | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гаалийн ерөнхий газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргуулах тухай | Төрийн албаны тухай хуулийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 34, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:<br>1. Осорын Ганбатыг Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гаалийн ерөнхий газрын даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх.<br>2. Энэ тогтоолын 1 дүгээрт нэр заасан иргэн Осорын Ганбатыг Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гаалийн ерөнхий газрын даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэгт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов |

| | | |
|---|---|---|
| 2 | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргуулах тухай | Төрийн албаны тухай хуулийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 32, 34, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:<br>1. Лувсандоржийн Баатар, Гомбодоржийн Цэцгээ, Домхүүгийн Энхцэцэг нарыг Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэд даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх.<br>2. Энэ тогтоолын 1 дүгээрт нэр заасан иргэдээс Лувсандоржийн Баатарыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэд даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүйн сайд Х.Тэмүүжинд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. |
| 3 | Завхан аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргуулах тухай | Завхан аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргуулах тухай хэлэлцэв. |
| 4 | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэд даргын албан тушаалд томилуулахаар санал болгосон албан хаагчид Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай | Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 22 дугаар зүйлийн 22.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд |

| | | |
|---|---|---|
| | | томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:<br>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын Бүртгэлийн ерөнхий газрын Бүртгэлийн хяналт, улсын бүртгэлийн архив, хяналт шинжилгээ, дотоод аудитын асуудал хариуцсан дэд даргын албан тушаалд Раднаасэдийн Даваадоржийг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүйн сайд Х.Тэмүүжинд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. |
| 5 | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газрын зарим удирдах албан тушаалд томилуулахаар санал болгосон албан хаагчид Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай<br>- Захиргаа, үйл ажиллагаа хариуцсан дэд дарга<br>- Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга<br>- Ажил худалдан авах хэлтсийн дарга | Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 22 дугаар зүйлийн 22.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:<br>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газрын Захиргаа, үйл ажиллагаа хариуцсан дэд даргын албан тушаалд Жигжиддоржийн Булгантамирыг томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Шадар сайд Д.Тэрбишдагвад санал болгох тухай Монгол Улсын төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.<br><br>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 22 дугаар зүйлийн |

| | | |
|---|---|---|
| | | 22.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:<br>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн даргын албан тушаалд Чойжилсүрэнгийн Жаргаланг, Ажил худалдан авах хэлтсийн даргын албан тушаалд Ганбаатарын Сэргэлэнбатыг томилуулахаар тус тус дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газрын дарга Д.Энхжаргалд санал болгох тухай Монгол Улсын төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов. |
| 6 | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Архивын ерөнхий газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэгийн 2013 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн ХЭГ/545 тоот албан бичиг, ажлын байрны тодорхойлолтоор Засгийн хэрэгжүүлэгч агентлаг Улсын архивын ерөнхий газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу сонгон шалгаруулалтыг 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, 2013 оны 6 дугаар сарын 13-14 өдөр зохион байгуулахаар тогтов. |
| 7 | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын бүртгэлийн ерөнхий газрын | Монгол Улсын Засгийн газрын гишүүн, хууль зүйн сайд Х.Тэмүүжингийн |

| | | |
|---|---|---|
| | тэргүүн дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай | 2013 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 1/1860 тоот албан бичиг, ажлын байрны тодорхойлолтоор Засгийн хэрэгжүүлэгч агентлаг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тэргүүн дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу сонгон шалгаруулалтыг 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, 2013 оны 6 дугаар сарын 13-14 өдөр зохион байгуулахаар тогтов. |
| 8 | Увс, Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай | Увс, Дорноговь **аймгийн Засаг даргын албан тоот бичиг, ажлын** байрны тодорхойлолтоор аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу сонгон шалгаруулалтыг 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдрөөс Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй дахин зарлаж, сонгон шалгаруулалтыг 2013 оны 6 дугаар сарын 13-14 өдөр зохион байгуулахаар болов. |
| 9 | Архангай, Говьсүмбэр аймгийн ИТХТ-ийн нарийн бичгийн албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай | **Архангай Говьсүмбэр аймгийн ИТХ-ын даргын албан тоот бичиг, ажлын** байрны тодорхойлолтоор аймгийн **ИТХТ-ийн нарийн бичгийн** даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу сонгон шалгаруулалтыг 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдрөөс Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй дахин зарлаж, сонгон шалгаруулалтыг 2013 оны 6 дугаар сарын 13-14 өдөр зохион байгуулахаар болов. |

| | | |
|---|---|---|
| | | |

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ